2021 оны 01 дүгээр сарын 29
№04 /1154/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



# Gerce(

## Moehgo& folo_ oa Heoll


| | | |
|---|---|---|
| 22, | \|roneiwirisdO HeldeBrl : \|wida - 19" - iia Ce* Deeeo& fca forioecilea Serkiiilek, Demecek, Neiik^ fda oa Jese( DO foijeKlK Soirk Noilokiie& l bigoregoleeO Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 233 |
| 23, | Gemsi( fca HemegeleeeO Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 246 |
| | | 249 |
| 24, | Neiik^ oa Degeoeeee& oa Simeoeki& Doilohcl il DorgeeeO Sioeki&, feldeehkua fca Cilokiiek Doeeel | |
| 25, | Gedegedo iia firkia O frkit Joil iia biide& oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 250 |
| 26, | folo_ oa DemdehdO iia Horiyemj l iia Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 270 |
| 27, | Joirice& oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 274 |
| 28, | Joirice& Silgea SiioeBrilek Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel | 276 |
| 29, | firkia O Nisk iia Doeeel Heoll do Nemelda forogoleeO Doeeel | 278 |

| | | | |
|---|---|---|---|
| 30, | Kimdo Kireit, Joiricek fca forioeciliea Serkiiilek Doeeel Heoll do Nemelda forogoleeO Doeeel | | 279 |
| 31, | Gedegedo iia firkia O frkit Joil iia biiidek oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll ii DegejO Moirdek Jiro^ oa Doeeel | | 281 |
| | **Moehgok folo_ oa yekit Horek oa Doeedegek** | | |
| 32, | Moehgok oa foiedosoa O folea Neiida iia Redio, Dwlwi_ oa foiedosoa O Joiblek oa kisiKa iie* Domileeo Doeeel | doge* 01 | 283 |
| 33, | Moehgok folo_ oa Yeroehkiiilehcl iia 2021 foa O fkljido Soehgogoll ii Doblea JerleeeO, Senek febeeO fdo* I DoeedegeeeO Doeeel | doge* 08 | 285 |
| 34, | Moehgok folo_ oa Yeroehkiiilehcl iia 2021 foa O fkljido Soehgogoll do Dwhniit Kirehsek Kirehlek Doeeel | doge* 07 | 287 |

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|---|---|---|
| 22. | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 233 |
| 23. | Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 246 |
| 24. | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай | 249 |
| 25. | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 250 |
| 26. | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 270 |
| 27. | Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 274 |
| 28. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 276 |
| 29. | Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 278 |
| 30. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | 279 |
| 31. | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 281 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 32. | Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай | Дугаар 01 | 283 |
| 33. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай | Дугаар 07 | 285 |
| 34. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай | Дугаар 08 | 287 |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:**

“4.1.9.“цахим худалдаа” гэж цахим сүлжээ ашиглан бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, хэлцэл хийх, төлбөр төлөх, хүргэж өгөх, хүлээж авах үйл ажиллагааг.”

**2/5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалт:**

“5.1.7.хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, сэтгэл зүйн дарамт, хохирол учруулж болзошгүй мэдээлэл тараахгүй байх.”

**3/7 дугаар зүйлийн 7.1.27-7.1.31 дэх заалт:**

“7.1.27.хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон, гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн барааны гаалийн бүрдүүлэлтийн горимд байрших хугацааг дэглэм цуцлах хүртэлх хугацаагаар сунгах, хугацаа хэтрүүлсний торгуулиас чөлөөлөх;

7.1.28.цар тахлын үед төрийн үйлчилгээг мэдээллийн технологи ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх;

7.1.29.төрийн байгууллага хооронд болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай цахим хэлбэрээр албан бичиг илгээх, хүлээн авах боломжийг бүрдүүлсэн солилцооны дундын системийг ашиглах;

7.1.30.шуудангийн үйлчилгээг цар тахлын үед тасралтгүй зохион байгуулах, хот доторх болон хот хоорондын бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх, цахим худалдааны цар хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах;

7.1.31.цар тахлын үед харилцаа холбоо, мэдээллийн технологи, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар, төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авах.”

**4/7[1] дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

“7[1].1.Цар тахлын үед иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх.”

**5/8 дугаар зүйлийн 8.1.6-8.1.8 дахь заалт:**

“8.1.6.халдварын тохиолдол, тэдгээрийн хавьтлыг олж тогтоох, илрүүлэх шинжилгээ авах, сорьц цуглуулах, тусгаарлах, хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, хөл хорионд орсон иргэдийг харьяалах оршин суух газарт зорчих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

8.1.7.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах;

8.1.8.цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний талаар холбогдох тушаал гаргах, дүрэм, журам, заавар, удирдамж батлах.”

**6/9 дүгээр зүйлийн 9.15-9.19 дэх хэсэг:**

“9.15.Коронавируст халдварыг оношлох**,** эмчлэх, урьдчилан сэргийлэх шинэ арга, аргачлалыг олон улсын, эсхүл үндэсний эмнэлзүйн туршилт**,** зөвлөмжид үндэслэн оношлогоо, эмчилгээнд хэрэглэх зааврыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.16.Харилцаа холбоо, эрчим хүч, шатахуун түгээх газрын сүлжээний найдвартай ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлыг шуурхай засварлах, үйлчилгээг сэргээх боломжийг бүрдүүлэх зорилгоор импортоор оруулж байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, машин техникт Гаалийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан түргэвчилсэн бүрдүүлэлт хийж болно.

9.17.Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор тухайн нутаг дэвсгэртээ дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, төлөвлөгөө, удирдамжийг батлан хэрэгжилтийг хангана.

9.18.Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журмыг Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга хамтран батална.

9.19.Хүнсний цахим болон шууд худалдааны зохицуулалт, зохион байгуулалт, худалдаа эрхлэгчид тавих эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн шаардлагыг тогтоосон журмыг холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн хүнсний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**2 дугаар зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль” гэсний өмнө “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “төрийн захиргааны төв” гэсний дараа “болон холбогдох бусад” гэж, 7.1.12 дахь заалтын “орон байр” гэсний дараа “, сайжруулсан түлш,” гэж, 7.1.14 дэх заалтын “эм, эмнэлгийн хэрэгсэл” гэсний өмнө “цар тахлаас хамааралгүйгээр хийгдэж байгаа бүтээгдэхүүний экспортыг хориглохгүй бөгөөд” гэж, 7.1.15 дахь заалтын “холбоотой” гэсний дараа “3 сараас доошгүй хугацааны” гэж, 7.1.24 дэх заалтын “Монгол Улсын Их Хурлын” гэсний өмнө “Монгол Улсын Ерөнхийлөгчийн,” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “комисс” гэсний дараа “болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт:**

“7.1.2.цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн

батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;”

**2/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт:**

“7.1.8.өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар теле, цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх журам батлах;”

**3/7 дугаар зүйлийн 7.1.21 дэх заалт:**

“7.1.21.коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох;”

**4/7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалт:**

“7.1.23.цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах;”

**5/8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт:**

“8.1.1.гадаад улсад байгаа Монгол Улсын иргэн буцаж ирэх хүсэлт гаргасан тохиолдолд тухайн улс дахь өвчлөлийн тархалт, эрсдэл, шууд нислэгийн боломж, бусад нөхцөл байдлыг харгалзан татан авах, тусгаарлах, хяналтад байлгах арга хэмжээг уян хатан байдлаар үе шаттайгаар зохион байгуулах;”

**6/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсэг:**

“9.3.Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9.4.Халдварт өвчнөөс хамгаалах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эмнэлгийн хэрэгсэл хангах нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага улсын хилээр оруулах бөгөөд хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**7/9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсэг:**

“9.12.Олон улсын шуудан солилцооны үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангаж, улс хоорондын шуудан илгээмжид Гаалийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан түргэвчилсэн бүрдүүлэлт хийж болно.”

**8/9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсэг:**

“9.14.Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй, оршин суух зөвшөөрөл аваагүй, визийн болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй бол тус нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд бүртгэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлнө.”

**9/12 дугаар зүйлийн 12.2.5 дахь заалт:**

“12.2.5.албан байгууллага, олон нийтийн газарт амны хаалт тогтмол зүүж, гараа угаах, хүн хоорондын зай барих;”

**4 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “Эд хөрөнгийн дайчилгаа” гэснийг “Эд хөрөнгө дайчлах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “буцах” гэснийг “харьяалалгүй хүн буцах, гарах” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “2020 оны 12 дугаар сарын 31-ний” гэснийг “2021 оны 6 дугаар сарын 30-ны” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.17 дахь заалтын “журмыг батлах” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# Moŋgol tolo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo*

folegeebigedo* Hoda

[illegible]

᠔ . ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠗ . ᠑ . ᠕ - ᠗ . ᠑ . ᠗ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ :

« ᠗ . ᠑ . ᠕ . [illegible] ᠂ [illegible] ᠂ [illegible] ᠃

᠗ . ᠑ . ᠖ . [illegible] ᠃

᠗ . ᠑ . ᠗ . [illegible] ᠄ »

᠕ . ᠘ . ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠘ . ᠑᠔ - ᠘ . ᠑᠘ ᠳᠠᠬᠢ ᠵᠦᠢᠯ :

« ᠘ . ᠑᠔ . [illegible] ᠄

᠘ . ᠑᠕ . [illegible] ᠄

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

2 . 8 ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 2 . 10 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ :

« 2 . 10 . ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠤᠶ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠬᠦ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠪᠠ ᠲᠤᠰ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 10 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠦᠷᠭᠡ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ... ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠨ᠎ᠠ ::»

2 . 7 ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 2 . 9 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ :

« 2 . 9 . ... ᠤᠨ ... ᠪᠠ ... ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ... ᠪᠣᠯᠤᠨ ... ᠶᠢᠨ ... ᠶᠢ ... ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠨ᠎ᠠ ::»

2 . 10 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 10 . 1 . 4 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ :

« 10 . 1 . 4 . ... ᠢᠯᠡᠷᠡᠭᠰᠡᠨ ... ᠪᠠ ... ᠶᠢᠨ ... ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠬᠦ ::»

3 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: ... ( ... – 2019 ) – ᠶᠢᠨ ... « ... » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « ... » ᠭᠡᠵᠦ ... 7 . 2 . 1 ... « ... » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « ... » ᠭᠡᠵᠦ ... « 2019 ᠣᠨ ᠤ 12 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 31 – ᠨ » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « 2020 ᠣᠨ ᠤ 6 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 30 – ᠨ » ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠡ ::

1 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: [illegible] ( ᠪᠤᠰᠤ – 96 ) – [illegible] 6 · 9 [illegible] 96 [illegible] « [illegible] » [illegible] ::

2 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: [illegible] ( ᠪᠤᠰᠤ – 96 ) – [illegible] 6 · 9 [illegible] 97 · 16 [illegible] 97 · [illegible] ::

3 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ 2021 ᠣᠨ ᠤ 6 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 09 – ᠨ – 6 [illegible] ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсэг:**

“22.10.Улсын онцгой комиссыг Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.”

**2/27$^{1}$ дүгээр зүйлийн 27$^{1}$.1.8 дахь заалт:**

“27$^{1}$.1.8.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах.”

**3/30 дугаар зүйлийн 30.1.19 дэх заалт:**

“30.1.19.энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах.”

**2 дугаар зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “гадна” гэсний дараа “тухайн нөхцөл байдалд нийцүүлэн” гэж, 10.4.11 дэх заалтын “улсын онц чухал” гэсний дараа “, төрийн тусгай хамгаалалтад байгаа” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “бууруулах” гэсний өмнө “сунгах,” гэж, 27$^{1}$ дүгээр зүйлийн 27$^{1}$.1.4 дэх заалтын “албан даалгавар” гэсний дараа “, тушаал” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтын “заавар,” гэсний дараа “салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.13 дахь хэсгийн “онцгой байдлын байгууллагад ажилласан” гэснийг “онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Коронавируст халдвар /Ковид19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг

нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

2 doge* Joii& . Gemsi( fca Hemegeleeeo Doeeel Heoll iia 10 doge* Joii& oa 10, 4 dekuA Kiseit oa « Gede% t » Kimehsea 0 Dere) t « Doeeel iia NoiKce& biide& do NeiiceKloa » Kijo, 10, 4, 11 dekuA Jigelda iia « folo_ oa foeca Cieeola » Kimehsea 0 Dere) t « , Doiro iia Doseel Hemegelelda do biii) t » Kijo, 11 doki* Joii& oa 11, 6 dekuA Kiseit oa « bigoregoleeo » Kimehsea 0 fmo% t « Soehgeeeo » Kijo, 27$_1$ doki* Joii& oa 27$_1$, 1, 4 dekuA Jigelda iia « felbia DegegelgeBrl » Kimehsea 0 Dere) t «, Dosiye& » Kijo, 28 doge* Joii& oa 28, 1, 5 dekuA Jigelda iia « JigeBrl » Kimehsea 0 Dere) t « SelBrl Hogoroedo iia Herilcea fejillegea 0 Doiloblekit, » Kijo Do_ Do_ Nemesokil .

3 doge* Joii& . Gemsi( fca Hemegeleeeo Doeeel Heoll iia 50 doge* Joii& oa 50, 13 dekuA Kiseit oa « foecogol biide& oa biigolol) t do fejilleeesea » Kimehsea I « foecogol biide& oa biigolol) t do Doiro iia Doseel felbit Hegeesea » Kijo foikirecilesokil .

4 doki* Joii& . fna Heoll il |ronewiroisdo HeldeBrl :|widA - 19" - iia Ce* Deeeo& fca forioecilea Serkiiilek, Demecek, Neiiki^, fdA oa Jese( DO foijeKlK SoirK Noilokile& I bigoregoleeo Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeo Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkulea Degejo Moirde% t .

Moehgo& folo_ oa
Yekit Hore& oa Dero) t          Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧИЙГ ТОРГОХ ШИЙТГЭЛ, АЛДАНГИАС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд шимтгэл төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.1.14, 5.1.15 дахь заалт:**

“5.1.14.“хамаарал бүхий этгээд” гэж гадаадын иргэний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхдийг;

5.1.15.“цахим виз” гэж гадаадын иргэнд цахим хэлбэрээр Монгол Улсын виз олгосныг нотлох цахим болон хэвлэмэл баримтыг.”

**2/9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт:**

“9.2.4.тухайлсан улсын иргэнийг Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлөх асуудлыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх;”

**3/9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалт:**

“9.3.5.энэ хуулийн 40.1.5-д заасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах;”

**4/9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт:**

“9.4.2.энэ хуулийн 13.3-т заасан журамд нийцүүлэн хилийн чанадад ажиллах виз мэдүүлгийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах;”

**5/11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэг:**

“11.8.Гадаадын иргэнд энэ хуулийн 5.1.12-т заасан визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын, нэг удаагийн, 30 хүртэлх хоногийн хугацаатай, орох визийг олон улсын хилийн боомт дээр олгож болно. Олон улсын хилийн боомт дээр визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын

виз олгож болох улсын жагсаалт, виз олгох журмыг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар зохицуулна.”

**6/16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэг:**

“16.2.Виз олгох байгууллага нь Монгол Улсын хууль тогтоомж болон виз олгох журмын дагуу зохих ангиллын визийг олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг сунгах, хүчингүй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

16.3.Тухайн ангиллын виз олгоход шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг биедээ авч яваа тохиолдолд энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу Монгол Улсын хилийн боомт дээр гадаадын иргэнд зохих ангиллын нэг удаагийн орох, дамжин өнгөрөх визийг олгож болно.”

**7/22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг:**

“22.2.энэ хуулийн 22.1.2-т заасан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.3.Монгол Улсад зорчих, эсхүл нэвтрэх зорилгоо тодорхойлж чадаагүй, зорчих зорилгодоо нийцээгүй ангиллын визтэй бол Монгол Улсад оруулахгүй байж болно.”

**8/27 дугаар зүйлийн 27.3.5 дахь заалт:**

“27.3.5.харьяалах улсын эрх бүхий байгууллагаас гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг хүчингүй болгосон.”

**9/27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг:**

“27.5.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.”

**10/32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг:**

“32.3.Энэ хуулийн 32.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ тус улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21

хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.”

**11/34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт:**

“34.2.4.шүүхээс иргэний хэрэг үүсгэж, тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж гарсан бол.”

**12/37 дугаар зүйлийн 37.9, 37.10 дахь хэсэг:**

“37.9.Энэ хуулийн 37.1.2, 37.1.12-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэн хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон, эсхүл эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүсэлт гаргасан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.3 дугаар зүйлийн 1.6-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн албадан гаргахаас чөлөөлөх эсэхийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ.

37.10.Албадан гаргасан гадаадын иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга сунгаж болно. Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгахтай холбоотой асуудлыг энэ хуулийн 9.2.3-т заасан журмаар зохицуулна.”

**13/40 дүгээр зүйлийн 40.1.6, 40.1.7 дахь заалт:**

“40.1.6.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах;

40.1.7.Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний гарах-орох мэдэгдлийг бүртгэх. Энэ мэдэгдлийг гадаадын иргэн Монгол Улсын хилээр гарах орохоосоо 72 цагаас доошгүй хугацааны өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.”

**14/40$^{1}$ дүгээр зүйл:**

**“40$^{1}$ дүгээр зүйл.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан**

40$^{1}$.1.Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн

нэгдсэн сан нь төрийн өмч байх бөгөөд улсын хилээр нэвтрэх зорчигчийн бүртгэлийн нэгдсэн сантай холбогдоно.

40$^{1}$.2.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын виз мэдүүлсэн, виз олгосон, виз олгохоос татгалзсан, Монгол Улсын хилээр нэвтэрсэн, Монгол Улсад түр ирэгч, албан хэргээр болон хувийн хэргээр оршин суусан, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан, албадан гаргахаас чөлөөлөгдсөн, Монгол Улсад тааламжгүй этгээдээр зарлагдсан зэрэг гадаадын иргэний талаарх цаасан болон цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

40$^{1}$.3.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлалыг хангах үүргийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

40$^{1}$.4.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх болон төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох, эрх бүхий байгууллага хамтран ашиглах боломжтой байна.

40$^{1}$.5.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

**2 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “Монгол Улсаас албадан гаргах” гэсний дараа “, албадан гаргахаас чөлөөлөх” гэж, 37 дугаар зүйлийн гарчгийн, 41 дүгээр зүйлийн 41.7.3 дахь заалтын “албадан гаргах” гэсний дараа “, албадан гаргахаас чөлөөлөх” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “байгууллагын дарга гаргана.” гэсний дараа “Гадаадын иргэн нь албадан гаргасан үндэслэлээс хамааран 1-10 жилийн хугацаанд Монгол Улсад орох эрхгүй байна.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/5 дугаар зүйлийн 5.1.11 дэх заалт:**

“5.1.11.“Монгол Улсын виз” гэж эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын хилээр нэвтрэх, Монгол Улсад тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг;”

**2/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:**

“8.1.4.Монгол Улсын үндэсний эв нэгдлийг бусниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хуульд нийцээгүй бусад аргаар явуулах, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг түгээх, сурталчлах, хэрэглэх;”

**3/9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт:**

“9.2.1.Монгол Улсын визийн ангилал болон визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Монгол Улсын виз олгох журам батлах;”

**4/9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалт:**

“9.4.1.хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөнөөр Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт визийн асуудал хариуцсан ажилтныг томилж, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;”

**5/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3.Виз нь хэвлэмэл болон цахим хэлбэртэй байж болно.”

**6/12 дугаар зүйл:**

**“12 дугаар зүйл.Цахим виз**

12.1.Цахим виз нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 9 дүгээр хавсралтын холбогдох стандартад нийцсэн байна.

12.2.Цахим виз олгохтой холбогдох харилцааг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар зохицуулна.”

**7/13 дугаар зүйл:**

**“13 дугаар зүйл.Визийн төв**

13.1.Визийн төв нь визийн мэдүүлэг хүлээн авах, хүлээн авсан визийн мэдүүлгийг виз олгох байгууллагад үнэн зөв, шуурхай дамжуулна.

13.2.Монгол Улсын визийн төвийн үйл ажиллагааг олон улс, эсхүл тухайн улсдаа энэ төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

13.3.Визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулан ажиллах журмыг Засгийн газар батална.”

**8/15 дугаар зүйл:**

**“15 дугаар зүйл.Визийн ангилал**

15.1.Тухайн гадаадын иргэний хилээр нэвтрэх зорилгыг үндэслэн тодорхой ангиллын виз олгоно. Аялал жуулчлалыг дэмжих зорилго бүхий өдрийн визийг хил дээр олгож болох бөгөөд тухайн виз нь зөвхөн хил орчмын жуулчинд хамаарна.

15.2.Визийн ангиллыг энэ хуулийн 9.2.1-д заасан журмаар тогтооно.”

**9/16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт:**

“16.1.3.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар.”

**10/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:**

“18.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг болон хоёр удаагийн орох виз нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэл 150 хоногийн хугацаанд хүчинтэй байна.”

**11/22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт:**

“22.1.2.нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн этгээд байвал;”

**12/24 дүгээр зүйл:**

**“24 дүгээр зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх**

24.1.Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.6-д заасны дагуу хил хамгаалах байгууллага нь биеийн давхцахгүй өгөгдлийг авч, улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

24.2.Энэ хуулийн 9.2.2-т заасан журамд энэ хуулийн 24.1-д заасан мэдээллийн санд биеийн давхцахгүй өгөгдлийг бүртгүүлэхээс чөлөөлөгдөх үндэслэлийг тусгана.

24.3.Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаарыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

24.4.Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно.

24.5.Энэ хуулийн 24.3, 24.4-т заасан зохицуулалтыг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна.

24.6.Гадаадын иргэнд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ энэ хуулийн 24.3-т заасан бүртгэлийн дугаарыг ашиглана.”

**13/40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалт:**

“40.1.4.гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн цаасан болон цахим мэдээллээс бүрдсэн нэгдсэн санг хөтлөх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;”

**4 дүгээр зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг” гэснийг “оршин суухаар ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг” гэж, мөн зүйлийн 5.1.6 дахь заалтын “Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг” гэснийг “ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээдийг” гэж, мөн зүйлийн 5.1.12 дахь заалтын “гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт” гэж, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтын “болон” гэснийг “, эсхүл” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтын дугаарыг “9.2.5” гэж, мөн зүйлийн 9.3.5 дахь заалтын дугаарыг “9.3.6” гэж, мөн зүйлийн 9.4.2 дахь заалтын дугаарыг “9.4.3” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “эхнэр, нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийн “гэр бүлийн гишүүний” гэснийг “хамаарал бүхий этгээдийн” гэж, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “хөдөлмөр эрхлэлт, боловсролын” гэснийг “хөдөлмөр эрхлэлтийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.9 дэх заалтын “захиргааны арга хэмжээ авагдсан” гэснийг “хуульд заасны дагуу хариуцлага хүлээсэн” гэж, мөн зүйлийн 37.5 дахь хэсгийн “паспорт, баримт бичигт Монгол Улсад орохыг хориглосон хугацааг заасан тэмдэглэл хийнэ.” гэснийг “тухай мэдээлэл, Монгол Улсад

орохыг хориглосон хугацааг гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд оруулна.” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтын “гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт” гэж, мөн зүйлийн 40.1.6 дахь заалтын дугаарыг “40.1.8” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “Захиргааны хариуцлагын тухай” гэснийг “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “30 хоногоос дээш хугацаагаар” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “гарах-орох,” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтын “энэ” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14, 17 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 18.5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgoe folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biiidee oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel

1 doki* Joiie . Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biiidee oa Doeeel Heoll dO Doo* t Doredoeesea fegol) t Del DeregekiA Joiie, Kiseit, Jigelda NemesoKil=

1, 5 doge* Joiie oa 5, 1, 14, 5, 1, 15 dekiA Jigelda=

« 5, 1, 14, « Hemiyeroe BiKl fdekioa » kiJO Gedegedo iia firkia 0 fkine*, NoiK*, Hemdorea femidoreeecl, fcikit, fkit, fBkit fcikit, fmekit fkit, kiokioa l,

5, 1, 15, « Ceki^ Wisa » kiJO Gedegedo iia firkia dO Ceki^ Kilbir1 bi* Moehgoe folo_ oa Wisa folgoeesea l NodeleeeO Ceki^ Bloa Kiblemee birimda il . »

2, 9 doki* Joiie oa 9, 2, 4 dekiA Jigelda=

« 9, 2, 4, Doeeiileeesea folo_ oa firkia l Moehgoe folo_ oa Wisa iia Zegerdel) t fca CilokilekK fesegodee l Gedegedo Herilcegea 0 Bloa Heoll Joil iia fesegodee frkilehsea DoirO iia JekiUrgea 0 Doie$ biiigolol) t iia Senee l foiedosolea SiioeBrilek, »

3, 9 doki* Joiie oa 9, 3, 5 dekiA Jigelda=

« 9, 3, 5, fna Heoll iia 40, 1, 5 - do Jigeeesea folea folo_ oa Bloa Gedegedo folo_ oa Doiro iia Bso biigolol) t iia SelBrl, Doilokilehcl iia Geje* DO Moehgo& folo_ DO foiila fejille) t YeBgoleeo Joibsiyere& folgoeeo, Soehgeeeo, Kicoa foikil Blgeeeo, foiila fejillegea do feno Kunelda Delbueeo Jiro^ bidoleeeo, »

4, 9 doki* Joii& oa 9, 4, 2 dekua Jigelda=

« 9, 4, 2, fna Heoll iia 13, 3 - do Jigeeesea Jiro^ do NeiiceKloa kull iia Cinedo do fejilleeeo Wisa MedeKlkit iia Doi$ oa biirisi& l Doeedegeeeo, Soehgoa Silgeregoleeo, Ki* t biigoleeo, »

5, 11 doki* Joii& oa 11, 8 dekua Kiseit=

« 11, 8, Gedegedo iia firkia do fna Heoll iia 5, 1, 12 - DO Jigeeesea Wisa iia Joibsiyere& foikil bi* « Jigolcia » feehkule& oa, Nikit fode) t iia, 30 Kirdelekua Hono( oa Hogoce) t Del, foroeeo Wisa il folea folo_ oa kull iia Bgomda Deki* t folgojo Blo% t. folea folo_ oa kull iia Bgomda Deki* t Wisa iia Joibsiyere& foikil bi* « Jigolcia » feehkule& oa Wisa folgojo Bleeo folo_ oa Jieesegelda, Wisa folgoeeo Jiro^ l fna Heoll iia 9, 2, 1 - do Jigeeesea Jiro^ iie* Jokucegolo% t. »

6, 16 doge* Joii& oa 16, 2, 16, 3 dekua Kiseit=

« 16, 2, Wisa folgoeeo biigolol) t feno Moehgo& folo_ oa Heoll Doeedegemjl Bloa Wisa folgoeeo Jiro^ oa Degedo Jokueeo feehkule& oa Wisa il folgoeeo, folgoeeo fca Dedegeljeeeo, feehkule& l foikirecilek, Hogoce) t il Soehgeeeo, Kicoa foikil Blgeeeo Biria frkit il Kirehjiklo% t.

16, 3, Doeel iia feehkule& oa Wisa folgoeeO dO Zegerdeeedeeeo birimda buciit oa fijl Birido& l bil t dO bia febcO YeB) t Dokuyeldo& dO fna Heoll iia 16, 1, 1, 16, 1, 2 - DO Jigeeesea biigolol) t fca folgoeesea Wisa iia Joibsiyere& oa DegegO Moehgo& folo_ oa kill iia Bgomda Deki* t GedegedO iia firkia dO JokeeO feehkule& oa Nikit fode) t iia foroeeO, Demjia foiehkirek Wisa il folgojO Blo% t. »

7, 22 doge* Joii& oa 22, 2, 22, 3 dekuA kiseit=

« 22, 2, fna Heoll iia 22, 1, 2 - DO Jigeeesea fbioecia O Jieesegelda il frek& MeedO iia Bloa Heoll Joil iia fesegode& frkulehsea Jese( oa Geje* oa kisika Hemdorea bidole% t.

22, 3, Moehgo& folo_ DO JorcieeO, fsek& t Nebderek Joril) t bia DodoreeeiilejO Cidegedol, JorcieeO Joril) t degea Neiicekidol feehkule& oa Wisa Del B& Moehgo& folo_ DO forogoleeO foikil biijO Blo% t. »

8, 27 doge* Joii& oa 27, 3, 5 dekuA Jigelda=

« 27, 3, 5, HeriyeleeeO folo_ oa frkit Bikl biigolol) t fca GedegedO iia firkia O pisPrDA, DeKa l foroleeeO birimda buciit l Kicoa foikil Blgeeesea. »

9, 27 doge* Joii& oa 27, 5 dekuA kiseit=

« 27, 5, Moehgo& folo_ DO HobuA iia kirelt iie* forosia SegoeeO Joibsiyere& febieeO Kiselda bia GedegedO iia firkia Do_ folo_ oa kill Nebderehsea fdo* fca Hoiisl 21 Hono( oa Dodo* t GedegedO iia firkia O fesegode& frkulehsea DoirO iia Jekurgea O biigolol) t dO Gerge% t. »

10, 32 doge* Joii& oa 32, 3 dekш Kiseit=

« 32, 3, fna Heoll iia 32, 1 - do Jigeeesea Gedegedo iia firkia forosia Segoeeo Joibsiyere& febeeo Kiselda bia Do_ folo_ oa Kull Nebderehsea fdo* fca Hoiisl 21 Hono( oa Dodo* t Gedegedo Herilcegea O fesegode& frkulehsea DoirO iia Jekurgea O Dois$ biigolol) t do fna Heoll iia 32, 2 - DO Jigeeesea Gedegedo iia firkia forosia Segoeeo Joibsiyere& febeeo Kiselda bia Do_ folo_ oa Kull Nebderehsea fdo* fca Hoiisl 21 Hono( oa Dodo* t Gedegedo iia firkia O fesegode& frkulehsea DoirO iia Jekurgea O biigolol) t dO Gerge% t. »

11, 34 doki* Joii& oa 34, 2, 4 dekш Jigelda=

« 34, 2, 4, SiKK fca firkia O Kireit fKskij0, Doeeel iia Gedegedo iia firkia I Moehgo& folo_ fca Gereeo ii Doi* DoidekiljeKlK Doeeel SiKK iia SiioeBrl, SiKhcl iia Jekuromjl Geroeesea B&. »

12, 37 doge* Joii& oa 37, 9, 37, 10 dekш Kiseit=

« 37, 9, fna Heoll iia 37, 1, 2, 37, 1, 12 - DO Jigeeesea Joirice& Gergeeesea Gedegedo iia firkia Hobш iia NoiKce& biide&, fero Ki* oa Gecieede&, Kimoa Hodeldogeleeeo Kimdo Kireit oa Hokureeecl Bloeesea, fseK& t freK& Meedo iia Kiedooekia foijeK Sildegea O fole^ fca Kiselda Gergeeesea, fseK& t freKO iia Kireit Kunea SiioeBrilek Doeeel Heoll iia 43, 3 doge* Joii& oa 1, 6 - do Jigeeesea foiedosole& BI Bloeesea Dokuyeldo& dO Gedegedo iia firkia O Kunelda iia folo_ oa biicegeeecl iia doiehnelda ii foiedosolea felbidea Gergeeeo fca CilokilеK fseK ii Gedegedo iia firkia O fesegode& frkulehsea DoirO iia Jekurgea O biigolol) t iia Dero) t SiioeBrile% t.

37, 10, felbidea Gergeeesea Gedegedo iia firkia O Moehgoa folo_ DO Dekia forogoleeO foikil biieeO Hogoce) t ii Gedegedo iia firkia O fesegodea frkulehsea DoirO iia Jekurgea O biigolol) t iia Dero) t Soehgejo Blo% t . Moehgoa folo_ DO Dekia forogoleeO foikil biieeO Hogoce) t ii SoehgeeeO Del HolB) t Del fesegodea l fna Heoll iia 9, 2, 3 - do Jigeeesea Jiro^ iie* Jokucegolo% t . »

13, 40 doki* Joiia oa 40, 1, 6, 40, 1, 7 dekiA Jigelda=

« 40, 1, 6, Moehgoa folo_ oa Heriyedo Kiokioa l Gedegedo iia firkia do foirecilekIK SiioeBrl Gergeeeo,

40, 1, 7, Moehgoa folo_ DO Cegecilea forosia SegoeeO Joibsiyerea feBeesea Gedegedo iia firkia O GereeO - foroeeO Medehdea l BirioekiK . fna Medehdea l Gedegedo iia firkia Moehgoa folo_ oa kill bi* GereeO foroeeO fca bia 72 Ce( fca Dogoeesl foikil Hogocegea O fmo% t Gedegedo iia firkia O fesegodea frkulehsea DoirO iia Jekurgea O biigolol) t do BirioekiKlo% t .

14, 40₁ doki* Joiia=

« 40₁ doki* Joiia . Gedegedo iia firkia O Wisa, Birioekia, Medekilea oa Nikidohsea Seeit

40₁, 1, Moehgoa folo_ feno Gedegedo iia firkia O Wisa, Birioekia, Medekilea oa Nikidohsea Seeit Del biii% t . Gedegedo iia firkia O Wisa, Birioekia, Medekilea oa Nikidohsea Seeit feno DoirO iia foimcl biieeO Bikioa folo_ oa kill bi* NebderekK Jorcieecl iia Birioekia oa Nikidohsea Seeit Del HolBeede% t .

40₁, 2, Gedegedo iia firkia O Wisa, Birioekia, Medekilea oa Nikidohsea Seeit fenO Moehgoa folo_ oa Wisa MedeKlohsea, Wisa folgoeesea, Wisa folgoeeO fca Dedegeljeeesea, Moehgoa folo_ oa kill bi* Nebderehsea, Moehgoa folo_ DO Doi* firehcl, felbia Kireit iie*

Bloa Hobla iia Kirit ii* forosia Segoeesea, Moengoq folo_ fca Gereeo ii DoidekiljeKlohsea, felbidea Gergeeesea, felbidea Gergeeeo fca CiloKilehdehsea, Moengoq folo_ DO Degelemjl foikil fdekioa ii* Jerleeedeeesea Jerkit Gedegedo iia firkia O Deq t bi* KiA Cegesoa Bloa Cekiv Medekileq oa Seeit fca Biridoq t.

40[1], 3, Gedegedo iia firkia O Wisa, Biriokeq, Medekileq oa Nikidohsea Seeit oa Nigocelaq l Heelgeeeo fKrkit ii Gedegedo iia firkia O fesegodeg frkilehsea Doiro iia Jekirgea O biigolol) t Kiliyeg t.

40[1], 4, Gedegedo iia firkia O Wisa, Biriokeq, Medekileq oa Nikidohsea Seeit oa Medekileq l Cekiv Kilbirl bi* BiridoKlK, KiljiKlK Bloa DoirO iia Medekileq oa Bsooa Seeit Del Medekileq Solilceeeo, frkit BiKl biigolol) t Hemdorea fesieleeeo Blomjl Del biiig t.

40[1], 5, Gedegedo iia firkia O Wisa, Biriokeq, Medekileq oa Nikidohsea Seeit oa Medekileq l fesieleeeo, Medekileq NeiiieKlK, Solilceeeo Jirov l Heoll Joil iia Bloa Gedegedo Herilcegea O fesegodeg frkilehsea Jese( oa Geje* oa KesiKoa Hemdorea bidoleg t. »

2 doge* Joiiq. Gedegedo iia firkia O frkit Joil iia biidag oa Doeeel Heoll iia 9 doki* Joiiq oa 9, 2, 3 dekiA Jigelda iia « Moengoq folo_ fca felbidea Gergeeeo » Kimehsea O Dere) t «, felbidea Gergeeeo fca CiloKilelK » Kijo, 37 doge* Joiiq oa Gerce( oa, 41 doki* Joiiq oa 41, 7, 3 dekiA Jigelda iia « felbidea Gergeeeo » Kimehsea O Dere) t «, felbidea Gergeeeo fca CiloKilelK » Kijo, 37 doge* Joiiq oa 37, 2 dekiA Kiseit oa « biigolol) t iia Dero) t Gergeg t. » Kimehsea O Dere) t « Gedegedo iia firkia fino felbidea Gergeeesea foiedosoleg fca Hemiyeroa 1 - 10 Jiq oa Hogocegea dO Moengoq folo_ DO foroeeO frkit foikil biiig t. » Kijo Do_ Do_ NemesoKil.

3 doge* Joiiq. Gedegedo iia firkia O frkit Joil iia biidag oa Doeeel Heoll iia DeregekiA Joiiq, Kiseit, Jigelda il Doo* t Doredoeesea ii* foiKircilea Neiiiregolsogel=

1, 5, doge* Joiig oa 5, 1, 11 dekA Jigelda=

« 5, 1, 11, « Moehgol folo_ oa Wisa » kijO frkit BiKl biigolol) t Fca folgoeesea Moehgol folo_ oa kUll bi* Nebderek, Moehgol folo_ DO Dodoreeel Hogocegea dO biiieeO Joibsiyereg l, »

2, 8 doge* Joiig oa 8, 1, 4 dekA Jigelda=

« 8, 1, 4, Moehgol folo_ oa foiedosoa O f$ Nikidog l Bsenigoleeo dO Cihlehsea foiila fejille) t YeBgoleeO, Herku_, Kimoeliit BsO Zesia O Sorgeg, Nomleg l DelkirekIK, Zesia O foiila fejille) t il Kimoa O frkit il Joiricehsea, Heoll dO Neiicekidol Bsooa fer) t bi* YeBgoleeO, Sedo* Semegoa, Meehsigoregoleeo f^, Seoekuca dO NoilokidO Bde_ l DoikikK, Sordeicileeeo, Kirehek, »

3, 9 doki* Joiig oa 9, 2, 1 dekA Jigelda=

« 9, 2, 1, Moehgol folo_ oa Wisa iia feehkuleg Bloa Wisa iia foiilecilekia O Kilosoa O Kimjil t il Doeedegeeo, Moehgol folo_ oa Wisa folgoeeO Jiro^ bidoleeO, »

4, 9 doki* Joiig oa 9, 4, 1 dekA Jigelda=

« 9, 4, 1, Heoll Joil iia fesegodeg frkulehsea Jese( oa Geje* oa KisiKa Del Joibsilcehsea iie* Moehgol folo_ fca Kull iia Cinedo dO Sego) t diplomeDA DoilokilehcI iia Geje* DO Wisa iia fesegodeg Herigoceeesea fejildea l Domilejo, Cilokilek fesegodeg l HolBeedeeeO Heoll Doeedegemjl dO Jigeeesea O Degego Jokiyea biigoleeO, »

5, 11, doki* Joiil oa 11, 3 dekUA Kiseit=

« 11, 3, Wisa fino Kiblemel Bloa Ceku^ Kilbiri Del biijO Blo% t. »

6, 12 doge* Joiil=

« 12 doge* Joiil. Ceku^ Wisa

12, 1, Ceku^ Wisa finO folea folo_ oa firkia O NisK iia Doeeel Ci/igo iia |nwwn]l iia 9 doki* Hebsorolda iia HolBeedeeeO SDenderDA DO Neiicehsea biii% t.

12, 2, Ceku^ Wisa folgoeeO Del HolBeedeeeO Herilce) t ii fna Heoll iia 9, 2, 1 - do Jigeeesea Jiro^ iie* Jokucegolo% t. »

7, 13 doge* Joiil=

« 13 doge* Joiil. Wisa iia Doi$

13, 1, Wisa iia Doi$ finO Wisa iia MedeKlkit Kiliyea febeeO, Kiliyea feBeesea Wisa iia MedeKlkit ii Wisa folgoeeO biigolol) t dO foinea Joi$, Sigoreeel Demjigolo% t.

13, 2, Moehgol folo_ oa Wisa iia Doi$ oa foiila fejille) t ii folea folo_, fseKl t Doeeel iia folo_ DO bia fna Doirol oa foiila fejille) t YeBgoleeO Doseeel Joibsiyerel Del Heoll iia fdekioa iie* KiiceoekiKlo% t.

13, 3, Wisa iia Doi$ oa biirisi& I Doeedegeeeo, Soehgoa Silgeregoleeo, Ki* t biigoloa fejilleeeO Jiro^ I Jese( oa Gej e*
bidole% t. »

8, 15 doge* Joii&=

« 15 doge* Joii&. Wisa iia feehkule&

15, 1, Doeeel iia Gedegedo iia firkia O kull bi* Nebderek Joril) t il foiedosolea Dodoreeel feehkule& oa Wisa folgo% t.
feyele& Jigolcile& I DemjiK Joril) t BiKl fdo* oa Wisa il kull Deki* t folgojO Bleeo Bikioa Doeeel iia Wisa finO Joibkia kull forci^ oa
Jigolcia dO Hemiyero% t.

15, 2, Wisa iia feehkule& I fna Heoll iia 9, 2, 1 - dO Jigeeesea Jiro^ iie* Doeedege% t. »

9, 16 doge* Joii& oa 16, 1, 3 dekuA Jigelda=

« 16, 1, 3, Moehgo& folo_ fca kull iia Cinedo dO Sego) t diplomeDA Doilokilehcl iia Gej e*. »

10, 18 doge* Joii& oa 18, 1 dekuA Kiseit=

« 18, 1, Moehgo& folo_ oa folea folo_ oa Ki* t dO foiki* t bi* Jigegedol B& Nikit Bloa Hoye* fode) t iia foroeeO Wisa finO
Gedegedo iia firkia Moehgo& folo_ oa kull bi* Nebderek Kirde& t 150 Hono( oa Hogocegea dO Kicoa Del biii% t. »

11, 22 doge* Joiiℓ oa 22, 1, 2 dekɯ Jigelda=

« 22, 1, 2, Neiida iia freKℓ Meedo do feyoℓ focerеgoljo Bljosl foikil HeldeBrido fbioecia iie* fbioecilehsea, fbioecilehsea biijo Bljosl foikil Siejl Demdeit filerehsea fdekioa biibiℓ, »

12, 24 doki* Joiiℓ=

« 24 doki* Joiiℓ. Gedegedo iia firkia l BirioekiK

24, 1, Gedegedo iia firkia l folo_ oa kɯll bi* NebdereK foil t do Moehgoℓ folo_ oa kɯll iia Doeeel Heoll iia 17, 6 - do Jigeeesea O Degego kɯll Hemegeleeeo biigolol) t feno bil t iia Debeeoceeeo foikil foihKhdeℓ l febcO, folo_ oa kɯll bi* Nebderehsea Jorcieecl iia Medekileℓ oa Nikidohsea Seeit do Birioeki% t.

24, 2, fna Heoll iia 9, 2, 2 - DO Jigeeesea Jiro^ do fna Heoll iia 24, 1 - do Jigeeesea Medekileℓ oa Seeit do bil t iia Debeeoceeeo foikil foihKhdeℓ l BirioekiKlK fca CilokilehdeK foiedosoleℓ l Doseee% t.

24, 3, felbia Bloa Hobɯ iia Kireit iie* forosia Segoeecl Gedegedo iia firkia do DeKa l Heriyeleeeo folo_ oa Dobcileℓ, Doirohsea foa, Se* t, fdo*, KiisO Jerkit foihKhdeℓ l bieedegeeesea Hogoroedo bia Debeeoceeeo foikil Birioekiℓ oa doge* l Gedegedo iia firkia O fesegodeℓ frkɯlehsea Doiro iia Jekɯrgea O biigolol) t folgo% t.

24, 4, Gedegedo iia firkia l foroa biirl bi* Heehgeeesea firkia, fejO feeeol iia Nikica, biigolol) t DeKa l Gedegedo iia firkia O fesegodeℓ frkɯlehsea Doiro iia Jekɯrgea O biigolol) t do 48 Ce( oa Dodo* t BirioekiKlK Bikioa Birioekiℓ l Cekɯ^ iie* Kɯjo Blo% t.

24, 5, fna Heoll iia 24, 3, 24, 4 - do Jigeeesea Jokucegololda ii fna Heoll iia 9, 2, 2 - DO Jigeeesea Jiro^ iie* Jokucegolo% t.

24, 6, Gedegedo iia firkia do DoirO iia foiiiecilekit foijeKlK dekia fna Heoll iia 24, 3 - do Jigeeesea Birioekiß oa doge* l fesieele% t.

13, 40 doki* Joiiß oa 40, 1, 4 dekua Jigelda=

« 40, 1, 4, Gedegedo iia firkia O Wisa, Birioekiß, Medekiileß oa Cegesoa Bloa Ceku^ Medekiileß fca Biridohsea Nikidohsea Seeit l KidolK, Seeit oa Hedegelelda, Hemegelelda iia feyoß foikil biiideß l Heehgeeeo, Seeit iie* Demjigoloa DoirO iia HolBeedeeeo biigolol) t Del Herilcea Medekiileß Soliicceeo, »

4 doki* Joiiß. Gedegedo iia firkia O frkit Joil iia biiideß oa Doeeel Heoll iia 5 doge* Joiiß oa 5, 1, 5 dekua Jigelda iia « Moehgoß folo_ DO 90 Hono( fca Dekihsl Hogoce) t bi* firehsea Gedegedo iia firkia l » Kimehsea l « forosia Segoeeo bi* firehsea Gedegedo iia firkia, DeKa O Hemiyeroß BiKl fdekioa l » kij0, Moia Joiiß oa 5, 1, 6 dekua Jigelda iia « Moehgoß folo_ DO 90 Hono( fca Dekihsl Hogoce) t bi* firehsea Gedegedo iia firkia, DeKa O Ki* Bill iia KisiKa l » Kimehsea l « firehsea Gedegedo iia firkia, DeKa O Hemiyeroß BiKl fdekioa l » kij0, Moia Joiiß oa 5, 1, 12 dekua Jigelda iia « Gedegedo folo_ DO Sego) t Moehgoß folo_ oa diplomeDA DoiloKiiehcl iia Gejje* DO » Kimehsea l « Moehgoß folo_ fca Kull iia CinedO do Sego) t diplomeDA DoiloKiiehcl iia Gejje* DO » kij0, 7 doge* Joiiß oa 7, 4, 5 dekua Jigelda iia « Bloa » Kimehsea l «, fseKß t » kij0, 9 doki* Joiiß oa 9, 2, 4 dekua Jigelda iia doge* l « 9, 2, 5 » kij0, Moia Joiiß oa 9, 3, 5 dekua Jigelda iia doge* l « 9, 3, 6 » kij0, Moia Joiiß oa 9, 4, 2 dekua Jigelda iia doge* l « 9, 4, 3 » kij0, 28 doge* Joiiß oa 28, 1 dekua Kiseit oa « fkine*, NoiK*, DoiroKlohsea fcikit, fkit, Kiokioa » Kimehsea l « Hemiyeroß BiKl fdekioa » kij0, Moia JoUß oa 28,2 dekua Kiseit oa « Ki* Bill Jia KisiKa O » Kimehsea

I Hemiyero& BiKI Fdekioa oa Kij0, 30 doge* Joii& oa 30, 1 dekUA Kiseit oa « Kidelmorl frkUlelda, Blbisore& oa » Kimehsea I « Kidelmorl frkUlelda iia » Kij0, 37 doge* Joii& oa 37, 1, 9 dekUA Jigelda iia « Jekurgea 0 fer) t Kimjil t feBeedeeesea » Kimehsea I « Heoll do Jigeeesea 0 Degeg0 Herigocel) t Kiliyehsea » Kij0, Moia Joii& oa 37, 5 dekUA Kiseit oa « pisPrDA, birimda buciit D0 Moehgo& folo_ D0 foroeeO il Horieeleeesea Hogoce) t il Jigeeesea Demdehle& Ki% t. » Kimehsea I « Doeeel Medekile&, Moehgo& folo_ D0 foroeeO il Horieeleeesea Hogoce) t il Gedegedo iia firkia 0 Medekile& oa Nikidohsea Seeit do forogolo% t. » Kij0, 40 doki* Joii& oa 40, 1, 3 dekUA Jigelda iia « Gedegedo folo_ D0 Sego) t diplomeDA Doilokilehcl iia Geje* D0 » Kimehsea I « Kull iia Cinedo do Sego) t diplomeDA Doilokilehcl iia Geje* D0 » Kij0, Moia Joii& oa 40, 1, 6 dekUA Jigelda iia doge* I « 40, 1, 8 » Kij0, 41 doki* Joii& oa 41, 7 dekUA Kiseit oa « Jekurgea 0 Herigocel) t iia Doeeel » Kimehsea I « Joirice& Silgea SiioeBrilek Doeeel » Kij0 Do_ Do_ foikirecilesokil .

5 doge* Joii& . Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biidee& oa Doeeel Heoll iia 10 doge* Joii& oa 10, 1 dekUA Kiseit oa « 30 Hono( fca Dekihsl Hogoce) t bi* » Kimehsea I, 11 doki* Joii& oa 11, 5 dekUA Kiseit oa « Gereeo - foroeeO, » Kimehsea I, 37 doge* Joii& oa 37, 1, 3 dekUA Jigelda iia « fna » Kimehsea I Do_ Do_ Hesosogel .

6 doge* Joii& . Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biidee& oa Doeeel Heoll iia 11 doki* Joii& oa 11, 4 dekUA Kiseit, 14, 17 doge* Joii&, 18 doge* Joii& oa 18, 3, 18, 4, 18, 5 dekUA Kiseit, 20 doge* Joii& oa 20, 2 dekUA Kiseit I Do_ Do_ Kicoa foikil Bloeesea d0 Dogecesogel .

7 doge* Joii& . fna Heoll il 2021 foa 0 6 doge* Se* t iia 01 - 0 fdo* fca fkulea Degej0 Moirde% t .

Moehgo& folo_ oa
Yekit Hore& oa Dero) t      Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:**

“6.4.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраас үзүүлэх энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 10.6-д заасан тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно. Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоохдоо гадаад улстай харилцан адил байх зарчмыг баримтлах бөгөөд уг хэмжээг гадаад валютаар тогтоож болно.”

**2/10 дугаар зүйлийн 10.6.30 дахь заалт:**

“10.6.30.гадаадын иргэний бүх төрлийн виз, визийн болон оршин суух зөвшөөрөл олгох хүсэлтийг хянан, энэ хуулийн 10.6.1, 10.6.2, 10.6.3, 10.6.4, 10.6.5, 10.6.6, 10.6.7, 10.6.9, 10.6.10, 10.6.11, 10.6.13, 10.6.15, 10.6.16, 10.6.17, 10.6.18, 10.6.19, 10.6.20, 10.6.21, 10.6.23, 10.6.24, 10.6.25, 10.6.26, 10.6.27, 10.6.28, 10.6.29-д заасан үйлчилгээг татгалзсан тохиолдолд тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.”

**2 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:**

“10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх үйлчилгээ үзүүлэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:”

**2/10 дугаар зүйлийн 10.6.15, 10.6.16 дахь заалт:**

“10.6.15.нэг удаагийн орох виз олгоход 115 000-270 000 төгрөг;

10.6.16.хоёр удаагийн орох виз олгоход 160 000-320 000 төгрөг;”

**3 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.3 дахь заалтын “7200-18 000” гэснийг “15 000-36 000” гэж, 10.6.9 дэх заалтын “1000-2500” гэснийг “10 000-15 000” гэж, 10.6.17 дахь заалтын “126 000-315 000” гэснийг “210 000-450 000” гэж, 10.6.18 дахь заалтын “252 000-630 000” гэснийг “460 000-750 000” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “10.6,” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.8, 10.6.12, 10.6.14, 10.6.22 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgo& folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

## folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll do Nemelda, folkirecilelda forogoleeO Doeeel

1 doki* Joii&. folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll do Doo* t Doredoeesea fegol) t Del DeregekAu Kiseit, Jigelda Nemesokil=

1, 6, doge* Joii& oa 6, 4 dekAu Kiseit=

« 6, 4, Moehgo& folo_ fca kAll iia CinedO dO Sego) t diplomeDA DoilokilehcI iia Gelje* fca foijeKlK fna Heoll iia 5, 1, 3, 5, 1, 4, 5, 1, 5, 10, 6 - dO Jigeeesea Demdehdo iia Horiyemjl, Wisa iia foiilecilekia O Kilosoa O Kimjil t il Jese( oa Gelje* Doeedege% t. Demdehdo iia Horiyemjl iia Kimjil t il DoeedegeeeO degea Gedegedo folo_ Del Herilcea fedell biiieeO Jerci^ l birimdeleeeO Bikioa fo( Kimjil t il Gedegedo WeloiDa bi* Doeedegej0 Blo% t. »

2, 10 doge* Joii& oa 10, 6, 30 dekAu Jigelda=

« 10, 6, 30, Gedegedo iia firkia O BiK Doiro& oa Wisa, Wisa iia Bloa forosia SegoeeO Joibsiyere& folgoeeO Kiselda il Kunea, fna Heoll iia 10, 6, 1, 10, 6, 2, 10, 6, 3, 10, 6, 4, 10, 6, 5, 10, 6, 6, 10, 6, 7, 10, 6, 9, 10, 6, 10, 10, 6, 11, 10, 6, 13, 10, 6, 15, 10, 6, 16, 10, 6, 17, 10, 6, 18, 10, 6, 19, 10, 6, 20, 10, 6, 21, 10, 6, 23, 10, 6, 24, 10, 6, 25, 10, 6, 26, 10, 6, 27, 10, 6, 28, 10, 6, 29 - dO Jigeeesea foiilecilekit il Dedegeljeeesea Dokiyeldo& dO Demdehdo iia Horiyemjl il Bcegea folgoeeO foiki. »

2 doge* Joii&. folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll iia DeregekAu Jigelda il Doo* t Doredoeesea iie* folkirecilea Neiiregolsogel=

1, 10 doge* Joii& oa 10, 6 dekAu Kiseit=

« 10, 6, Gedegedo iia firkia, Heriyele& foiki Kimoa do Moehgo& folo_ oa Wisa, forosia Segoeeo Joibsiyere& folgoeeo, Wisa, forosia Segoeeo Joibsiyere& oa Kiselda ii Kuneeeo, Birioekik foiilecilekit foijeKlK do Doo* t Doredoeesea Kimjil t bi* Demdehdo iia Horiyemjl Horiye% t= »

2, 10 doge* Joii& oa 10, 6, 15, 10, 6, 16 dekiA Jigelda=

« 10, 6, 15, Nikit fode) t iia foroeeo Wisa folgoeeo do 115 000 - 270 000 DoiKriit,
10, 6, 16, Hoye* fode) t iia foroeeo Wisa folgoeeo do 160 000 - 320 000 DoiKriit, »

3 doge* Joii&. folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll iia 10 doge* Joii& oa 10, 6, 3 dekiA Jigelda iia « 7200 - 18 000 » Kimehsea l « 15 000 - 36 000 » Kijo, 10, 6, 9 dekiA Jigelda iia « 1000 - 2500 » Kimehsea l « 10 000 - 15 000 » Kijo, 10, 6, 17 dekiA Jigelda iia « 126 000 - 315 000 » Kimehsea l « 210 000 - 450 000 » Kijo, 10, 6, 18 dekiA Jigelda iia « 252 000 - 630 000 » Kimehsea l « 460 000 - 750 000 » Kijo Do_ Do_ foikirecilesokil.

4 doki* Joii&. folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll iia 6 doge* Joii& oa 6, 2 dekiA Kiseit oa « 10, 6, » Kimehsea l Hesosogel.

5 doge* Joii&. folo_ oa Demdehdo iia Horiyemjl iia Doeeel Heoll iia 10 doge* Joii& oa 10, 6, 8, 10, 6, 12, 10, 6, 14, 10, 6, 22 dekiA Jigelda ii Do_ Do_ Kicoa foiki Bloeesea do Dogecesogel.

6 doge* Joii&. fna Heoll ii Gedegedo iia firkia O frkit Joil iia biiide& oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeo Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkulea DegejO Moirde% t.

Moehgo& folo_ oa Yekit Hore& oa Dero) t Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/14.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Олон улсын нислэг үйлдэгч агаарын тээвэрлэгч нь зорчигчийн мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргүүлээгүй, эсхүл мэдээллийг дутуу хүргүүлсэн бол агаарын тээвэрлэгч хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2/16.2 дугаар зүйлийн 1.5 дахь заалт:**

“1.5.ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын дугаарыг “1.6” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgo& folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo*    folegeebigedo* Hoda

## Joirice& oa Doeeel Heoll dO Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel

1 doki* Joii& . Joirice& oa Doeeel Heoll dO Doo* t Doredoeesea fegol) t Del DeregekUA Kiseit, Jigelda Nemesokil=

1, 14, 8 doge* Joii& oa 6 dekUA Kiseit=

« 6, folea folo_ oa Nisolkit foiiledohcl fege* oa DekiBrilehcl finO Jorcieecl iia Medekile& l firkia O fege* oa Kilkit KikirK fca fmo% t frkit BiKl biigolol) t dO Kiedooekia foijek Sildegea foikil bi* KirkiKlokidol, fseK& t Medekile& l DodegO KirkiKlohsea B& fege* oa DekiBrilehcl Heoll iia fdekioa l DeBa Miehgea Nikica Del Deehcek Kimjiyea O DoiKriit iie* Dorge% t . »

2, 16, 2 doge* Joii& oa 1, 5 dekUA Jigelda=

« 1, 5, firehsea Joril) t fca bia foiki* t foiila fejille) t YeBgoloeesea, »

2 doge* Joii& . Joirice& oa Doeeel Heoll iia 16, 2 doge* Joii& oa 1, 5 dekUA Jigelda iia doge* l « 1, 6 » KijO foikirecilesokil .

3 doge* Joii& . fna Heoll il GedegedO iia firkia O frkit Joil iia biide& oa Doeeel Heoll dO Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkulea DegejO Moirde% t .

Moehgo& folo_ oa Yekit Hore& oa Dero) t    Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2 дахь заалтын “7.3 дугаар зүйл,” гэсний дараа “14.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.24 дэх заалтын “14.8” гэснийг “14.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

## Joirice& Silgea SiioeBrilek Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel

1 doki* Joii& . Joirice& Silgea SiioeBrilek Doeeel Heoll iia 1, 8 doge* Joii& oa 6, 2 dekuA Jigelda iia « 7, 3 doge* Joii&, » Kimehsea 0 Dere) t « 14, 8 doge* Joii& oa 6 dekuA Kiseit, » KijO Nemesokil .

2 doge* Joii& . Joirice& Silgea SiioeBrilek Doeeel Heoll iia 1, 8 doge* Joii& oa 6, 24 dekuA Jigelda iia « 14, 8 » Kimehsea I « 14, 8 doge* Joii& oa 1, 2, 3, 4, 5 dekuA Kiseit » KijO foikirecilesokil .

3 doge* Joii& . fna Heoll ii GedegedO iia firkia 0 frkit Joil iia biiide& oa Doeeel Heoll dO Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkulea DegejO Moirde% t .

Moehgo& folo_ oa
Yekit Hore& oa Dero) t      Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний нисэхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 30.4 дэх хэсэг нэмсүгэй:

“30.4.Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгч нь олон улсын нислэг үйлдэхдээ зорчигчийн мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрөхөөс өмнө Монгол Улсын эрх бүхий байгууллагад урьдчилан хүргүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

**Moehgol folo_ oa Heoll**

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

**firkia 0 NisK iia Doeeel**
**Heoll dO Nemelda forogoleeO Doeeel**

1 doki* Joiia . firkia 0 NisK iia Doeeel Heoll iia 30 doge* Joiia dO Doo* t Doredoeesea fegol) t Del 30' 4 dekiA Kiseit Nemesokil=

« 30' 4' folea folo_ oa Nisolkit foiileoeK Fege* oa DeKiKiBrilehcl finO folea folo_ oa Nisolkit foiileoeK dekia Jorcieeci iia Medekileg I firkia O fege* oa Kilkit KikirK fca fmo% t Moehgol folo_ oa firkit BiKl biigolol) t dO forioecilea KirkiKlo% t . »

2 doge* Joiia . fna Heoll ii Gedegedo iia firkia 0 firkit Joil iia biidea oa Doeeel Heoll dO Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkilea Degejo Moirdeo% t .

Moehgol folo_ oa
Yekit Horea oa Dero) t Go' {eedeesidc* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/8 дугаар зүйлийн 8.2.10 дахь заалт:**

"8.2.10.Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах."

**2/25 дугаар зүйлийн 25.1.10 дахь заалт:**

"25.1.10.энэ хуулийн 8.2.10-т заасан зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgo& folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

## Kimdo Kireit, Joirice& fca forioecilea Serkiiilek Doeeel Heoll do Nemelda forogoleeO Doeeel

1 doki* Joii& . Kimdo Kireit, Joirice& fca forioecilea Serkiiilek Doeeel Heoll do Doo* t Doredoeesea fegol) t Del Deregeku Jigelda Nemesoki=

1, 8 doge* Joii& oa 8, 2, 10 deku Jigelda=

« 8, 2, 10, folea folo_ oa Nisolkit foiileoek feege* oa DekiBrilehcl fca Jorcieecl iia Medekile& l forioecilea febeeO . »

2, 25 doge* Joii& oa 25, 1, 10 deku Jigelda=

« 25, 1, 10, fna Heoll iia 8, 2, 10 - do Jigeeesea Jorcieecl iia Medekile& l forioecilea febeeO, Herilcea Medekile& Solilceeeo, DeKa 0 feyo& foiki biiide& l Heehgeeeo Jiro^ bidoleeeO . »

2 doge* Joii& . fna Heoll ii Gedegedo iia firkia 0 frkit Joii iia biiide& oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkulea Degejo Moirde% t .

Moehgo& folo_ oa
Yekit Hore& oa Dero) t Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтын 24.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг Засгийн газар, түүний харьяа байгууллага нь холбогдох бусад байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулна.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

## Moehgoڤ folo_ oa Heoll

2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* folegeebigedo* Hoda

### Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biiideڤ oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll il DegejO Moirdek Jiro^ oa Doeeel

1 doki* Joiiڤ. 2020 foa 0 12 doge* Se* t iia 31 - 0 fdo* bidoleeesea Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biideڤ oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll iia 3 doge* Joiiڤ oa 12 dekui Jigelda iia 24, 1 dekui Kiseit DO Jigeeesea foiila fejille) t il Jese( oa Gejle*, DeKa 0 Heril t biigolol) t feno HolBeedeeeO Bsooa biigolol) t Del Hemdorea foil t Zedo Del bi* Jokiyea biigolo% t.

2 doge* Joiiڤ. fna Heoll il Gedegedo iia firkia 0 frkit Joil iia biideڤ oa Doeeel Heoll do Nemelda, foikirecilelda forogoleeO Doeeel Heoll Kicoa DeKlde* Bloeesea fdo* fca fkilea DegejO Moirde% t.

Moehgoڤ folo_ oa
Yekit Horeڤ oa Dero) t Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот |

**Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Дэшигрэнцэнгийн Оюун-Эрдэнийг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgol folo_ oa Yekit Horel oa Doeedegel

2021 foa 0 01 dok:* Se* t iia 08 - 0 fdo* doge* 01 foleqeebigedo* Hoda

## Moehgol oa foiedosoa 0 folea Neiida iia Redio, Dwlwwi[A oa foiedosoa 0 Joib;el oa KisiKa iie* Domileeeo Doeeel

Moehgol folo_ oa Yekit Horel oa Cigolgea 0 Horeldogea 0 Diit oa Doeeel Heoll iia 108 doge* Joiil oa 108, 2 dekuA Kiseit, folea Neiida iia Redio, Dwlwwi[A oa Doeeel Heoll iia 21 dok:* Joiil oa 21, 2, 21, 8 dekuA Kiseit l foiedosolea Moehgol folo_ oa Yekit Horel fca DoeedegeeeO fenO=

1, Moehgol oa foiedosoa 0 folea Neiida iia Redio, Dwlwwi[A oa foiedosoa 0 Joib;el oa KisiKa iie* Desihriecea 0 foyoa - frdeoI il Domilesogel .

2, fna Doeedegel l 2021 foa 0 01 dok:* Se* t iia 07 - 0 fdo* fca fkulea Degej0 Moirdesok:l .

Moehgol folo_ oa Yekit Horel oa Dero) t Go, {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал авах өдрийг 2021 оны 6 дугаар сарын 09-ний өдөр байхаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# Moehgo& folo_ oa Yekit Hore& oa Doeedege&

2021 foa 0 01 doki* Se* t iia 20 - 0 fdo* doge* 07 folegeebigedo* Hoda

## Moehgo& folo_ oa Yeroehkiilehcl iia 2021 foa 0 fkiljido Soehgogoll ii Dob;ea Jerleee0 , Sene& febee0 fdo* l Doeedegeee0 Doeeel

Moehgo& folo_ oa foiedosoa Heoll iia Horia DeBdoge* Joii& oa 1 dekɯ kiseit oa 3 dekɯ Jigelda , Moehgo& folo_ oa Yeroehkiilehcl iia Soehgogoll iia Doeel Heoll iia 8 doge* Joii& oa 8 , 1 , 8 , 2 dekɯ kiseit l foiedosolea Moehgo& folo_ oa Yekit Hore& fca Doeedegeee0 feno=

1 , Moehgo& folo_ oa Yeroehkiilehcl iia fkiljido Soehgogoll ii 2021 foa 0 01 doki* Se* t iia 25 - 0 fdo* fca fkɯlek bi* Dob;ea Jerlesogel .

2 , Moehgo& folo_ oa Yeroehkiilehcl iia feeheeea Zedoa 0 Soehgogoll iia Sene& febee0 fdo* l 2021 foa 0 06 doge* Se* t iia 09 - 0 Fdo* biiiee0 bi* Doeedegesogel .

3 , fna Doeedege& l 2021 foa 0 01 doki* Se*T iia 20 - 0 fdo* fca fkɯlea Degej0 Moirdesoki l .

Moehgo& folo_ oa
Yekit Hore& oa Dero) t Go , {eedeeside* t

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр — Дугаар 08 — Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмж хэрэглэхийг тус тус зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

## Moehgog folo_ oa Yekit Horeg oa Doeedegeg

2021 foa 0 01 doki* Se* t iia 20 - 0 fdo* doge* 08 folegeebigedo* Hoda

**Moehgog folo_ oa Yeroehkiiilehcl iia 2021 foa 0**
**fkiljido Soehgogoll do Dwhniit Kirehseg Kireh;ek Doeeel**

Soehgogoll iia feoiDomeDjigoloeesea SisDw^ oa Doeeel Heoll iia 6 doge* Joiig oa 6, 1, 1 dekuA
Jigelda ii foiedosolea Moehgog folo_ oa Yekit Horeg fca Doeedegeeeo fenO=

1, Moehgog folo_ oa Yeroehkiiilehcl iia 2021 foa 0 fkiljido Soehgogoll iia Soehgoeecioa oa
Birioekig oa foiila fejillegea do Birioekig oa Dwhniit Kirehseg l, Seneg febeeO, DogeleeeO, doieit GergeeeO foiila
fejillegea do « Niyoa fimija /isDA » Seneg DogeleeeO DoiKkiromjl Kireh;eK il Do_ Do_ Joibsiyeresokil .

2, fna Doeedegeg l 2021 foa 0 01 doki* Se*T iia 20 - 0 fdo* fca fkulea DegejO Moirdesokil .

Moehgog folo_ oa
Yekit Horeg oa Dero) t Go, {eedeeside* t

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 3.75
**Индекс: 200003**